

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг-Ус ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2024/07/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.15 № 307
танай _____ ны № _____ т

“ТЭШИГ-УС” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ П.ОЮУНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ нь гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого 424.3 сая төгрөгийг төвлөрүүлж, нийт зардлын гүйцэтгэл 439.1 сая төгрөг буюу 90.6% хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 45.04 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Булган аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/734 захирамжаар шууд гэрээ байгуулах эрхийг нээж 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 103/2022 дугаартай гэрээг “Долоон бар” ХХК-тай байгуулан орон нутгийн төсвөөс шинээр 90.0 сая төгрөгөөр халаалтын тогоо худалдан авч 23.0 сая

000020701

төгрөгийн өөрийн хөрөнгөөр “Долоон бар” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан суурилуулж мөн шинэ тогоо суурилуулсантай холбоотой зуухны хэсгийн механикийн хэсгийн шугамын шинэчлэлийг 20.5 сая төгрөгөөр хийсэн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	47,791,910.48	80,457,996.78
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,072,670.73	133,930,849.80
Нийт хөрөнгийн дүн	52,864,581.21	214,388,846.58
Нийт өр төлбөрийн дүн	21,456,243.42	78,107,029.18
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	31,408,337.79	136,281,817.40
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	52,864,581.21	214,388,846.58
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	52,864,581.21	214,388,846.58
Үйл ажиллагааны зардлын дүн	364,930,634.77	409,078,743.89
Үйл ажиллагааны үр дүн	17,240,583.76	14,456,813.93
Үйл ажиллагааны бус үр дүн	1,568,630.31	0
Үйл ажиллагааны нийт үр дүн	15,671,953.45	14,456,813.93
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		31,408,337.79
Тайлант оны үр дүн		969,171,412.83
Эцсийн үлдэгдэл		14,456,813.93
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	422,756,391.12	432,592,840.21
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	421,739,467.04	442,357,202.13
Үйл ажиллагааны ЦМГ	1,016,924.08	-9,764,361.92
Хөрөнгө оруулалтын ЦМГ		
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,805,865.48	21,822,789.56
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,822,789.56	12,058,427.64
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
Урсгал зардал		
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Гурав. Аудитын илрүүлэлт

Илрүүлэлт-1:

Аудитаар нийт 130,034.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 130,034.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Тэшиг сумын ЭМТ-өөс суудлын УАЗ 469 авто машиныг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/04 тушаалаар хүлээн авах шийдвэр гарч 2023 оны 8 сарын 16-ны өдөр хүлээлцсэн акт үйлдэж хүлээн авсан, 90 сая төгрөгийн уурын зуухны тогоо, 76м урттай шугам хоолойг тус тус орлогот аваагүйг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтыг үндэслэж залрууллаа.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 2,548.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,548.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,548.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,557.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Томилолтын зардалтай холбоотой.

Илрүүлэлт:

Томилолтын хуудасгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, хаалгаагүй томилолт олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй.

2. Дэмжлэг туслалцаатай холбоотой.

Д.Чулуунд 200.0 мянган төгрөгийн буцалтгүй дэмжлэг туслалцааг Дотоод журмын 11 дүгээр зүйлийн 11.11 дэх заалтаар олгосон боловч дотоод журамд тус заалтыг тусгаагүй заалтаар олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцээгүй.

3.Тээвэр шатахууны зардалтай холбоотой.

Тээвэр шатахууны зардлаас зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй шатахууны зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцээгүй.

2.2 Албан шаардлага

533 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны 9 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэшиг сумын ЭМТ-өөс суудлын	1	130,034.8	1	130,034.8								

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

УАЗ 469 авто машиныг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/04 тушаалаар хүлээн авах шийдвэр гарч 2023 оны 8 сарын 16-ны өдөр хүлээлцсэн акт үйлдэж хүлээн авсан, 90 сая төгрөгийн уурын зуухны тогоо, 76м урттай шугам хоолойг тус тус орлогот аваагүй.												
Дүн	1	130,034.8	1	130,034.8								

Шилэн дансны 9 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн.					1	0
Дүн					1	0
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>						
Дүн						
Нийт дүн						
